# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Галт сумын ТТЗ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2026/007/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: Х.Энхтуяа

Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/330

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА М.ДОЛЖИНЖАВ
ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Галт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санаахүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хасах тодотгол хийсэнтэй холбоотойгоор 32.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагнал, худалдан авах ажиллагаа, өр төлбөр, орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь биелүүлээгүй 6.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 4 зөвлөмж хүргүүллээ.

### Бусад асуудлын хэсэг

Галт сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны үр дүнгийн гэрээг 81.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,600,625.2 | 2,326,649.4 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 1,144,054.4 | 1,522,766.0 |
| 3 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 231,805.2 | 165,315.7 |
| 4 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 224,185.9 | 637,987.7 |
| 5 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | 580.0 | 580.0 |
| 6 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 5,195,505.2 | 4,947,371.8 |
| 7 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | 196,758.2 | 169,595.2 |
| 8 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 4,998,747.0 | 4,777,776.6 |
| 9 | Биет хөрөнгө | | 4,851,936.6 | 4,633,252.2 |
| 10 | Биет бус хөрөнгө | 13 | 146,810.4 | 144,524.4 |
| **11** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **6,796,130.4** | **7,274,021.2** |
| 12 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 21,015.5 | 115,593.4 |
| 13 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 21,015.5 | 115,593.4 |
| 14 | Өглөг | | 21,015.5 | 115,593.4 |
| 15 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 6,775,114.9 | 7,158,427.8 |
| 16 | Засгийн газрын хувь оролцоо | | 6,775,114.9 | 7,158,427.8 |
| 17 | Засгийн газрын оруулсан капитал | | 1,227,591.4 | 1,227,591.4 |
| 18 | Хуримтлагдсан үр дүн | | 4,106,244.6 | 4,489,557.5 |
| 19 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 1,441,278.9 | 1,441,278.9 |
| **20** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **6,796,130.4** | **7,274,021.2** |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 3,631,050.8 | 3,592,187.681 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 1,946,128.5 | 2,191,002.6 |
| 3 | Орлогын албан татвар | | 856,729.5 | 820,957.6 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | | 856,729.5 | 820,957.6 |
| 5 | Хөрөнгийн албан татвар | | 73,474.8 | 87,020.6 |
| 6 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 1,015,924.1 | 1,283,024.3 |
| 7 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 364,302.7 | 1,401,185.0 |
| 8 | Тусламжийн орлого | | 0.0 | 816,455.2 |
| 9 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,320,619.6 | 0.0 |
| 10 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 2,322,342.1 | 3,166,259.2 |
| 11 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,322,342.1 | 3,166,259.2 |
| 12 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,212,987.1 | 2,270,255.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 846,352.04 | 1,005,851.0 |
| 14 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 105,793.94 | 124,890.5 |
| 15 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 430,752.91 | 504,326.5 |
| 16 | Хангамж, бараа материалын зардал | | 89,202.49 | 76,300.4 |
| 17 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 89,547 | 54,770.9 |
| 18 | Томилолт, зочны зардал | | 7,600 | 5,775.4 |
| 19 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 123,161.8 | 64,505.9 |
| 20 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 520,577.0 | 433,835.1 |
| 21 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 109,355.0 | 896,003.7 |
| 22 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | | 1,308,708.7 | 425,928.4 |
| 23 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 24,988 | 42,615.5 |
| 24 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | | -24,988 | -42,615.5 |
| 25 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | | 1,283,720.7 | 383,312.9 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 3,278,908.34 | 3,447,107.13 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,877,535.45 | 2,191,002.6 |
| 3 | Орлогын албан татвар | 856,729.52 | 820,957.63 |
| 4 | Хөрөнгийн албан татвар | 73,474.84 | 87,020.63 |
| 5 | Бусад татвар, төлбөр, хураамж | 947,331.09 | 1,283,024.34 |
| 6 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 38,424.51 | 124,901.74 |
| 7 | Газрын төлбөр | 24,253.39 | 14,850.65 |
| 8 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 884,653.19 | 1,143,271.95 |
| 9 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 80,753.32 | 1,256,104.53 |
| 10 | Нийтлэг татварын бус орлого | 80,753.32 | 253,298.25 |
| 11 | Тусламжийн орлого | 0.0 | 816,455.18 |
| 12 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 186,351.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,320,619.58 | 0.0 |
| 14 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,007,784.23 | 2,738,037 |
| 15 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,007,784.23 | 2,738,037 |
| 16 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,965,726.83 | 1,914,573.45 |
| 17 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 848,409.34 | 1,005,161.02 |
| 18 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 103,736.64 | 124,597.38 |
| 19 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 430,392.91 | 471,613.73 |
| 20 | Хангамж, бараа материалын зардал | 81,207.29 | 61,480.24 |
| 21 | Эд хогшил, урсгал засварын зардал | 88,449 | 58,400.9 |
| 22 | Томилолт, зочны зардал | 7,600 | 5,775.4 |
| 23 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 110,245.76 | 61,053.88 |

| | | | |
|---|---|---|---|
| 24 | Бараа үйлчилгээний бусад зардал | 295,685.9 | 126,490.91 |
| 25 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,057.4 | 823,463.55 |
| 26 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 1,271,124.11 | 709,070.13 |
| 27 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 423,153.72 | 298,358.2 |
| 28 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 423,153.72 | 298,358.2 |
| 29 | Дотоод эх үүсвэрээр | 423,153.72 | 298,358.2 |
| 30 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -423,153.72 | -298,358.2 |
| 31 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 89,000 | 32,000 |
| 32 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -89,000 | -32,000 |
| 33 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 758,970.39 | 378,711.93 |
| 34 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 385,083.7 | 1,144,054.09 |
| 35 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,144,054.09 | 1,522,766.02 |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,491,394.2 | 5,491,394.2 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 8,096.0 | 8,096.0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,499,490.2 | 5,499,490.2 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -8,096.0 | -8,096.0 |
| 5 | Тайлант үеийн үр дүн | 1,283,720.7 | 1,283,720.7 |
| 6 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,775,114.9 | 6,775,114.9 |
| 7 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 6,775,114.9 | 6,775,114.9 |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,775,114.9 | 6,775,114.9 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 383,312.9 | 383,312.9 |
| 10 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 7,158,427.8 | 7,158,427.8 |

### 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,675,937.2** | **2,248,415.5** | **427,521.7** | **84.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,180,602.8** | **1,940,906.9** | **239,695.9** | **89.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,121,842.8** | **1,887,156.4** | **234,686.4** | **88.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,012,520.5** | **996,369.8** | **16,150.7** | **98.4** |
| 210101 | Үндсэн цалин | 502,506.0 | 481,318.7 | 21,187.3 | 95.8 |
| 210102 | Нэмэгдэл | 410,518.8 | 399,242.2 | 11,276.6 | 97.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,936.0 | 34,602.5 | -24,666.5 | 348.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 89,559.7 | 81,206.4 | 8,353.3 | 90.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **126,615.2** | **124,597.4** | **2,017.8** | **98.4** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,114.2 | 85,819.7 | 294.5 | 99.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,125.2 | 11,487.8 | -1,362.6 | 113.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,062.7 | 4,843.2 | 219.5 | 95.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,062.7 | 4,690.7 | 372.0 | 92.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,250.4 | 17,756.1 | 2,494.3 | 87.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **579,880.4** | **469,551.7** | **110,328.7** | **81.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 104,557.3 | 64,234.0 | 40,323.3 | 61.4 |
| 210302 | Түлш, халаалт | 462,156.8 | 397,086.1 | 65,070.7 | 85.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,166.3 | 8,231.6 | 4,934.7 | 62.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **72,733.8** | **54,895.0** | **17,838.8** | **75.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,065.8 | 4,970.4 | 2,095.5 | 70.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,358.0 | 26,301.5 | 13,056.5 | 66.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,000.0 | 4,099.8 | 900.3 | 82.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 850.0 | 402.0 | 448.0 | 47.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,360.0 | 8,660.9 | 699.2 | 92.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,100.0 | 10,460.5 | 639.5 | 94.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **73,196.5** | **73,150.5** | **46.0** | **99.9** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,199.6 | 11,199.6 | 0.0 | 100.0 |
| 210602 | Тавилга | 8,500.0 | 8,500.0 | 0.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 53,496.9 | 53,450.9 | 46.0 | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **10,000.0** | **5,775.4** | **4,224.6** | **57.8** |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,000.0 | 5,775.4 | 4,224.6 | 57.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **86,918.4** | **49,890.2** | **37,028.2** | **57.4** |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 83,918.4 | 49,563.6 | 34,354.8 | 59.1 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200.0 | 0.0 | 1,200.0 | 0.0 |
| | Даатгалын үйлчилгээ | 100.0 | 100.0 | 0.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,000.0 | 0.0 | 1,000.0 | 0.0 |
| | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200.0 | 44.0 | 156.0 | 22.0 |
| 210807 | Газрын төлбөр | 500.0 | 182.6 | 317.4 | 36.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **159,978.0** | **112,926.4** | **47,051.6** | **70.6** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 89,678.0 | 84,373.4 | 5,304.6 | 94.1 |
| 210902 | Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал | 70,300.0 | 28,553.0 | 41,747.0 | 40.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **58,760.0** | **53,750.6** | **5,009.5** | **91.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **58,760.0** | **53,750.6** | **5,009.5** | **91.5** |
| | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,960.0 | 36,960.0 | **0.0** | **100.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 21,800.0 | 16,790.6 | 5,009.5 | 77.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **406,084.4** | **275,508.6** | **130,575.8** | **67.8** |
| 223001 | Бусад хөрөнгө | 406,084.4 | 275,508.6 | **130,575.8** | **67.8** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **89,250.0** | **32,000.0** | **57,250.0** | **35.9** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 89,250.0 | 32,000.0 | 57,250.0 | 35.9 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,675,937.2** | **2,627,127.6** | **48,809.6** | **98.2** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 2,033,577.3 | 2,403,899.7 | -370,322.4 | 118.2 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 86,750.0 | 32,000.0 | 54,750.0 | 36.9 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,500.0 | 4,876.8 | 3,623.2 | 57.4 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 359,256.0 | | 359,256.0 | 0.0 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 187,853.9 | 186,351.1 | 1,502.8 | 99.2 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 1,144,054.0 | -1,144,054.0 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,522,766.0 | -1,522,766.0 | |

**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлант он |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **50,116.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **50,116.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **50,116.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **8,791.2** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8,791.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,062.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,062.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,585.3** |
| 210401 | Бичиг хэрэг | 140.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,634.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 311.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,499.1 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,200.0** |
| 210604 | Урсгал засвар | 1,200.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | **18,063.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,063.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,414.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,414.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,000.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **50,116.7** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **50,116.7** |
| 1311103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,414.5 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,516.8 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,185.4 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Галт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 5.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1 албан шаардлага гарсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 6.6 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн болно.

**5.1 Зөвлөмж**

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Өр төлбөртэй холбоотой асуудал**

*1.1Аудитын илрүүлэлт:*

Тайлант онд төсвийн хасах тодотгол хийснээс төсөвт байгууллагуудын тогтмол зардалд 32.5 сая төгрөгийн, санхүүжилт хүрэлцээгүй, зарим дансны эрх хаасан зэргээс 83.1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", санхүүгийн тайлангийн "*нийцсэн бөгөөд зохистой байх*" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Үүссэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, цаашид өр төлбөр үүсэхгүй байхад анхаарч, халаалтын зардлыг нэмэгдсэн үнэ тарифаар санхүүжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж ажиллах

**2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

*2.1 .Аудитын илрүүлэлт:*

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 6.6 сая төгрөгөөр 3-н нэр төрлийн орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.”*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “*Эрх үүрэг*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж

Орлогыг нэр төрлөөр нь жигд хanган биелүүлэх

**3. Орлогын данстай холбоотой асуудал**

*3.1 .Аудитын илрүүлэлт:*

Сумын Төрийн сангийн ерөнхий орлогын дансны тайланг журнал бичиж, нягтлан бодох бүртгэл хөтлөхгүйгээр тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 "*төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дараалаар гүйцэтгэнэ", 14.3.2 "журналд бичих" санхүүгийн тайлангийн "*нийцсэн бөгөөд зохистой байх*" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын төрийн сангийн ерөнхий орлогын дансны тайланг гаргаж хэвших

**4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

*4.1 Аудитын илрүүлэлт:*

Орон нутгийн хөгжлийн сангийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "сумын төсвийн 3-н худаг засвар", "1-р хорооны худаг засвар, ухаалаг тоолуур тавих" мөн тус 2 төсөл арга хэмжээг 1 худаг дээр хийгдэх ажил байтал төсөвт өртгийг жижиглэн шууд худалдан авах аргыг сонгохоор төлөвлөсөн байна.

*Өгсөн зөвлөмж*

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын www.fas.audit.mn цахим системд 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТТЗ | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |
| Харьяа байгууллагуудын алдаа | | | | | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 1.0 | 1 | 1.0 | | | 1 | 1.0 | | | | |
| **Дүн** | **1** | **1.0** | **1** | **1.0** | | | **1** | **1.0** | | | | |
| Нийт дүн | **1** | **1.0** | **1** | **1.0** | | | **1** | **1.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТТЗ | 4 | 6.6 | | | | | 4 | 6.6 | | | | |
| **Дүн** | **4** | **6.6** | | | | | **4** | **6.6** | | | | |
| **Харьяа байгууллагуудын зөрчил** | | | | | | | | | | | | |
| ЗДТГ | 2 | 5.9 | 1 | 0.5 | 1 | 5.4 | | | | | | |
| Дүн | **2** | 5.9 | **1** | **0.5** | **1** | **5.4** | | | | | | |
| **Дүн** | **6** | **12.5** | **1** | **0.5** | **1** | **5.4** | **4** | **6.6** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТТЗ | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |
| **Харьяа байгууллагуудын зөрчил** | | | | | | | | | | | | |
| **ЗДТГ** | 3 | 4.9 | 3 | 4.9 | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **4.9** | **3** | **4.9** | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР Х.ЭНХТУЯА ОГНОО: 2026.03.25